



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 02/69

Баян-Өндөр сум


**Аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2025 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 341,163,048,972 (гурван зуун дөчин нэгэн тэрбум нэг зуун жаран гурван сая дөчин найман мянга есөн зуун далан хоёр) төгрөгөөр, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 262,844,711,088 (хоёр зуун жаран хоёр тэрбум найман зуун дөчин дөрвөн сая долоон зуун арван нэгэн мянга наян найм) төгрөгөөр тус тус баталсугай.

2. Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ